

ТҮҮХ, ЭДИЙН ЗАСАГ, СОЁЛ

**АЛС ДОРНОДЫН ХУВЬСГАЛТ БАЙГУУЛЛАГУУДЫН
АНХДУГААР ИХ ХУРАЛ, ТҮҮНД МОНГОЛЫН
ТӨЛӨӨЛӨГЧИД ОРОЛЦСОН НЬ****Ж. Урангуа**

МАХН анх үүссэн цагаасаа эхлэн олон улсын коммунист хөдөлгөөнтэй нягт харилцаа холбоо тогтоохыг чухалчилдаг байжээ. МАХН-ын анхны программд: «Харгисыг халах, боловсролыг ургаш дэвшихийг эрмэлзэх ард ирэгний эрхийг нийтэд тэгшлэн засах гэсэн Хятад, Оросын зэрэг гадаад олон улсын хувьсгалын намуудтай нэвтрэлцэн найрамдаж харилцан туслалцахыг хичээнэ»¹ гэж заасан байна.

Үүнийг хэрэгжүүлсэн нэг бодит баримт бол МАН, МХЗЭ-ийн төлөөлөгчид 1922 оны эхээр хуралдсан Алс Дорнодын хувьсгалт байгууллагуудын анхдугаар их хурал ажиллагаанд идэвхтэй оролцсон явдал юм. Монголын төлөөлөгчид анх удаа олон улсын коммунист, хувьсгалт байгууллагуудын их хурал дээр Монголын ард түмэн харийн түрэмгийллийн эсрэг олон арван жил тэмцсээр ирсэн түүхэн замнал, түүнийг МАН хэрхэн удирдаж ардын хувьсгалыг ялалтанд хүргэсэн, хувьсгалт ололтоо хамгаалж, ардчилсан өөрчлөлт хийж эхлэж байгаа зэрэг улс орныхоо дотоод байдал, манжийн түрэмгийлэгчид, Хятадын цэргийн эрхтнүүд, Японы империализм зэрэг олон улсын харгис хүчний явууллагад дүн шинжилгээ хийж, Монголын ард түмний тэмцэл ялалтад нөлөөлсөн гадаад хүчин зүйл, нэн ялангуяа ЗОУ-ын ялгуулсан ажилчин, тариачидтай ангийн холбоо тогтоон тэмцсэн, Коминтернээр удирдуулсан олон улсын коммунист хөдөлгөөний тус дэмжлэгийг өндөр үнэлжээ.

Тэр үед дорнодахины колони, хараат орнуудын дотроос хамгийн түрүүнд ялгуусан пролетарийн орны тусламжтайгаар империализм, феодализмыг эсэргүүцсэн ардын хувьсгалыг амжилттай хийж, төрийн тусгаар тогтнолоо байлдан олсон Монголын ард түмний ялалтын ач холбогдлыг Хятадын цэргийн эрхтнээс эхлээд олон улсын империалист харгис хүчин элдвээр гуйвуулж байгаа явдалд Монголын төлөөлөгчдийн хэлсэн үг, тавьсан илтгэл, их хурлын баримт бичгүүд жинтэй няцаалт болсноор барахгүй, Монгол Ардын хувьсгалыг үнэн зөвөөр сурталчлах, түүний ололтыг харгис хүчний халдлагаас өмгөөлөн хамгаалахыг нэг ёсондоо олон улсын хувьсгалчдад уриалсан уриа болжээ.

Империалистууд дэлхийн нэгдүгээр дайныг дэгдээж, өөр хоорондоо хүчээ үзэлцэн туйлдаж байсан үед Орос орон Октябрийн социалист их хувьсгал ялж дэлхийн анхны социалист орон Зөвлөлт

Орос Улс тогтсон нь дэлхийн бөмбөрцөгт дангаараа ноёрхож байсан капитализмыг ерөнхий хямралд оруулсан юм. Октябрийн социалист их хувьсгал дэлхий дахины дарлагдсан улс түмэнд хувьсгалжуулагч нөлөө үзүүлж, тэдэнд эрх чөлөөний төлөө хэрхэн тэмцэж, яаж ялахын үлгэр загвар болж, түүний чөлөөлөгч үзэл санаа нь улс түмний хувьсгалт тэмцлийн замыг гийгүүлэгч бамбар болсон билээ.

Империалист харгис хүчин нь ЗОУ ба олон улсын хувьсгалт хөдөлгөөнийг нухчин дарахын тулд хүчээ нэгтгэж хамтран тэмцэх талаар хэлэлцэн тохиролцох Вашингтоны бага хурлыг 1922 онд хийжээ. Түүний дараа, тэр үеийн олон улсын коммунист хөдөлгөөний төв штаб—Коммунист Интернационалын санаачлага, удирдлагаар зохих бэлтгэл хийсний дараа 1922 оны 1-р сарын 24-нд Зөвлөлт Орос Улсын нийслэл Москва хотноо Кремлийн ордонд Алс Дорнодын хувьсгалт байгууллагуудын анхдугаар их хурал нээгдсэн байна. Их хурал В. И. Ленинийг хүндэт даргаараа сонгожээ. Алс Дорнодын хувьсгалт байгууллагуудын анхдугаар их хуралд Алс Дорнодын коммунист, хувьсгалт байгууллагууд, хөдөлмөрчин эмэгтэйчүүд, хувьсгалт залуучуудын байгууллагын төлөөлөгчид оролцжээ.

Их хуралд туслах эрхтэй 131, зөвлөх эрхтэй 17 төлөөлөгч оролцсоны дотор Индонез, Монгол, Солонгос, Хятад, Энэтхэг, Япон зэрэг улсууд, түүнчлэн ЗОУ-ын буриад, якут зэрэг үндэстний төлөөлөгчид байв.

Тэр үед дорнодахины орнуудын улс төрийн тэмцлийн тавцанд ажилчин анги товойн гарч, коммунист нам, бүлгүүд үүсэн бэхжиж байв. Үндэсний эрх чөлөөний хөдөлгөөнд залуучууд, эмэгтэйчүүд идэвхтэй оролцож байсан үед Коминтерний удирдлагаар хийгдсэн энэ их хурлын бүрэлдэхүүнийг авч үзэхэд Коминтерн, залуучуудын Коммунист Интернационал үнэхээр олон улсын байгууллага болсон нь илт байв. Эдгээр байгууллага зөвхөн өрнөдийн ажилчин ангид нөлөө үзүүлээд зогсоогүй, түүнчлэн дорнодахины дарлагдсан хөдөлмөрчин олон түмэнд нөлөөтэй болсон байв.

Иймээс тус их хурлын гол зорилго нь империализмын эсрэг өрнө, дорнын хувьсгалт хөдөлгөөнийг нэгтгэхэд оршиж байжээ.

Алс Дорнодын хувьсгалт байгууллагуудын анхдугаар их хурал нь Алс Дорнодын коммунист, хувьсгалт байгууллагуудын, Алс Дорнодын орнуудын хөдөлмөрчин эмэгтэйчүүдийн, Алс Дорнодын хувьсгалт залуучуудын их хурлуудын хэлбэрээр гурван секцид хуваагдан хуралджээ. Үүнд :

а) **Алс Дорнодын коммунист, хувьсгалт байгууллагуудын анхдугаар их хуралд** олон улсын байдал ба Вашингтоны бага хурлын тухай Коммунист Интернационалын Гүйцэтгэх Хороо (КИГХ)-ын илтгэл, орон тус бүрийн төлөөлөгчдийн илтгэл, үндэстний ба колонийн асуудлын талаар коммунистуудын баримтлах байр суурь, коммунистууд үндэсний хувьсгалт намуудтай хамтран ажиллах тухай зэрэг асуудал хэлэлцэхээр тогтжээ.

КИГХ-ноос оруулсан илтгэлд тухайн үеийн олон улсын байдлын онцлог шинжийг тодорхойлон Ази, Алс Дорнодын орнууд дахь хувьсгалт хөдөлгөөний асуудлыг ихээхэн анхаарчээ. Дайны дараа Азийн улс түмний хувьсгалт тэмцлийн далайц, эрч хүчин улам улмаар нэмэгдэж Алс Дорнодын асуудлыг урьдахаас улам чухал болгон, түүнийг бүх дэлхийн бодлого, пролетари ба дарлагдсан ард түмнүүдийн эрх чөлөөний хөдөлгөөний тэнхлэг болгож байгааг илтгэгч цохон заагаад, Ази тив, Алс Дорнодын орнуудад АНУ-аас явуулж буй шунахай бодлогыг илчлэв.

Солонгос, Хятад, Монгол зэрэг орон тус бүрийн байдлыг илтгэгч тодорхойлохын зэрэгцээ тус их хуралд дарлагдсан орны төлөөлөгч-

дөөс гадна дарлагч үндэстний доторхи, тухайлбал хувьсгалт чиглэлийн төлөөлөгчид, Японы дэвшилт олон нийтийн төлөөлөгчид хүрэлцэн ирснийг цохон тэмдэглэж, Алс Дорнодын асуудлыг шийдвэрлэхэд Японы пролетари нарын роль их байгааг дурьджээ. Уг илтгэлт тэр үеийн олон улсын харилцааны байдлыг нэгтгэн дүгнээд, ЗОУ-д эхэлсэн хувьсгалт үйл явцыг цаашид өрнүүлэхэд олон улсын эв санааны нэгдлийг бататгах нь цаг үеийн шаардлага мөн гэж үзжээ.

Үүнтэй холбогдуулан их хурлаас баталсан тогтоолд: «Солонгос, Хятад, Монголын болон Алс Дорнодын хөдөлмөрчин ард олон нь Зөвлөлт Орос Улстай холбоо тогтоон империалист дарлалын хүлээсийг таслан, ажилчин, тариачдын ах дүүгийн холбоонд үндэслэсэн чөлөөт байгууллагыг тогтоож чадвал л боолын байдлаас гарч, өөрсдийн орны байгалийн барагдашгүй баялгийг ашиглаж чадна»² гэж их хурал заасан байна.

Их хурлын хэлэлцсэн хоёр дахь асуудал нь орон тус бүрийн төлөөлөгчдийн илтгэл байв. Хуралд оролцсон Алс Дорнодын орнуудын хөдөлмөрчдийн төлөөлөгчид илтгэлдээ өөрсдийн орны байдал, түүнээс үндэслэн гарч буй үндэсний болон нийгмийн эрх чөлөөний зорилтуудыг тодорхойлжээ.

Их хурлын хэлэлцэх хэргийн гуравдахь асуудал нь «Үндэстэн ба колонийн асуудалд коммунистуудын баримтлах байр суурь, үндэсний хувьсгалт намуудтай тэдний хамтран ажиллах нь» гэдэг илтгэл байлаа. Түүнийг Коминтерний дорнод хэлтсийн эрхлэгч Г. Сафаров тавьжээ. Илтгэгч илтгэлдээ, дэлхийн I дайны дараа капиталист системийн аж ахуй хямралтай байгаа, империалист улсууд хямд ажлын хүч, хэрэгцээтэй зах зээл олж авахын төлөө өрсөлдөн тэмцэж байгааг Алс Дорнодын жишээн дээр дурьдсан байна.

Колони, хагас колони орнууд дахь хөрөнгөтний ардчилсан хөдөлгөөн нь үндэсний эрх чөлөөгөө олох зорилт тавьж гадаадын империализмын эсрэг үнэхээр чиглэсэн байвал коммунистууд дэмжих тухай, нөгөөтэйгүүр дотоодын харгис хүчний эсрэг тэмцэх, империализмын тулгуур болж байгаа феодализмын үлдэгдлийг арилгах зэрэг асуудлыг В. И. Ленинээс Коминтерний их хуралд тавьсан илтгэлийн үзэл санааны дагуу хөндөж тавьсан байна.

Үндэсний эрх чөлөөний төлөө тэмцэлд ажилчин анги онцгой үүрэгтэй, эрх чөлөөний төлөө тэмцэлд Алс Дорнодын хүн амын олонхи болж буй тариачдыг татан оролцуулахын чухлыг заажээ.

Их хурал Коминтерний оруулсан энэхүү илтгэлийг хэлэлцээд коммунист намууд үндэсний хувьсгалт байгууллагуудтай харилцах тухай асуудлаар санал нэгтэй тогтоол баталжээ. Уг тогтоолд империализмд дарлагдсан Алс Дорнодын хөдөлмөрчин олон түмэн үндэсний ба нийгмийн эрх чөлөөгөө зөвхөн олон улсын пролетари нартай холбоо тогтоосноороо олж чадна гэж үзээд, нэг талаас үндэсний хувьсгалт хөдөлгөөн, нөгөө талаас хөдөлмөрчдийн нийгмийн эрх чөлөөний төлөө тэмцлийн хоорондын харилцааг зөвөөр ойлгохын чухлыг онцлон тэмдэглэсэн байна.³

б) Алс Дорнодын орнуудын хөдөлмөрчин эмэгтэйчүүдийн анхдугаар зөвлөгөөнд Алс Дорнодын эмэгтэйчүүдийн байгууллагуудын 7 төлөөлөгч оролцож, 5 үндсэн асуудлыг хэлэлцэхдээ, өрнө дахинд III интернационалаар удирдуулсан коммунист намуудын жолоодлогоор эмэгтэйчүүд олон улсын коммунист хөдөлгөөнд хэрхэн оролцож байгаагийн тоймыг сонсож, Зөвлөлт Орос Улсын ажилчин, тариачин эмэгтэйчүүдийн тухай асуудлыг ихэд сонирхжээ.

2. Первый съезд революционных организаций Дальнего Востока. Сборник. Пг. 1922. с. 68.

3. «Проблемы востоковедения», 1960 он. № 5, 83-р тал

Эмэгтэйчүүдийн зөвлөлгөөнд оролцсон төлөөлөгчид өөрсдийн орны эмэгтэйчүүлийн байдлын тухай мэдээлэл, хийж хувьсгалт эмэгтэйчүүдийн ирээдүйн байгууллагын улс төрийн хөтөлбөр, зохион байгуулалтын зарчмын тухай тохиролцжээ.⁴ Анхдугаар зөвлөлгөөн «Алс Дорнодын хөдөлмөрчин эмэгтэйчүүдэд гаргасан уриа» баримт бичгийг баталж, түүнд Хятад, Солонгос, Япон зэрэг орны эмэгтэйчүүд дарлал мөлжлөгт хэрхэн зүдэрч байгаа «Алс Дорнодын орнуудын хөдөлмөрчин эмэгтэйчүүдийн дунд зохиох ажлын үндсэн зарчим, зорилго, арга хэлбэрийн тухай тогтоол» гаргаж, Алс Дорнодын эмэгтэйчүүдийг капиталын эсрэг пролетари нарын тэмцэлд татан оролцуулах, эмэгтэйчүүдийг нийгмийн амьдралын бүх салбарт эрх чөлөөтэй болгохын төлөө эрчимтэй тэмцэх, хөдөлмөрчин эмэгтэйчүүдийн ангийн ухамсар, олон улсын эв санааны нэгдлийг сэргээх, орон тус бүрийн коммунист байгууллагуудын дэргэд хөдөлмөрчин эмэгтэйчүүдийн дунд ажил зохиох хэлтсүүдийг байгуулах, тийм хэлтсүүд нь Коминтерний олон улсын эмэгтэйчүүдийн нарийн бичгийн дарга нарын газрын харьяанд буй байгууллагуудын бүрэлдэхүүнд багтаж эмэгтэй пролетари олон түмний дунд хувьсгалын ажлыг удирдаж байвал зохино⁵ гэж заажээ.

Тус зөвлөлгөөн Алс Дорнодын орнуудын дарлагдсан эмэгтэйчүүдийг улс төрийн амьдралд, тухайлбал империализмын эсрэг эрх чөлөөний хувьсгалт тэмцэлд татан оролцуулахад чухал үүрэг гүйцэтгэсэн байна.

в) **Алс Дорнодын хувьсгалт залуучуудын анхдугаар их хурал** 1922 оны I сарын 30-наас эхлэн 3 өдөр үргэлжилж түүнд Алс Дорнодын орнуудын залуучуудын 30-аад байгууллагыг төлөөлсөн 70 орчим төлөөлөгч оролцжээ.⁶

Их хуралд КИГХ-ын нэрийн өмнөөс баяр хүргэж Унгарын коммунистуудын удирдагч Бела Кун үг хэлжээ. Алс Дорнодын хувьсгалт залуучуудын анхдугаар их хурал нь Залуучуудын Коммунист Интернационал, түүнээс Алс Дорнодын залуучуудын хувьсгалт хөдөлгөөнд хандах тухай, орон тус бүрийн төлөөлөгчдийн илтгэл, Алс Дорнодын залуучуудын хөдөлгөөний зорилт зэрэг асуудлуудыг хэлэлцээд, Алс Дорнодын залуучуудад хандан тунхаг гаргав.

«Залуучуудын Коммунист Интернационал, түүнээс Алс Дорнодын залуучуудын хувьсгалт хөдөлгөөнд хэрхэн хандах тухай» гэсэн илтгэлийг Залуучуудын Коммунист Интернационалын Гүйцэтгэх Хорооны гишүүн Рихард Шиллер тавьж хэлэлцүүлжээ. Илтгэгч Залуучуудын Коммунист Интернационал байгуулагдсан түүхийг өгүүлээд, түүний II их хурлын шийдвэрүүд, ялангуяа колони орнуудын залуучуудын дунд зохиох ажлын тухай чухал санал дэвшүүлээ.

Залуучуудын Коммунист Интернационалын II их хурал Дорнодахины залуучуудын “хөдөлгөөний шинж байдал, зорилтыг тодорхойлохдоо, залуучуудын эдийн засгийн байдал, тэднийг үндэстний ба соёлын талаар дарлаж байгаа. Тэд шашны мухар сүсгээс ихээхэн хөндий байгаа зэрэг нь тэднийг хамгийн хувьсгалч хүчин болгож байгаа учраас колонийн залуучуудын үүсч буй хөдөлгөөний өмнө хот, хөдөөгийн өргөн олон хөдөлмөрчин залуучуудыг үндэстний хувьс-

4. «Первый съезд революционных организаций Дальнего Востока». Петроград. 1922. с. 333

5. «Первый съезд революционных организаций Дальнего Востока» с. 358.

6. Дурьдсан эмхтгэл. 311-р тал.

галт тэмцэлд зохион байгуулалттай татан оролцуулж, тэднийг нийгмийн хувьсгалын үзэл санаагаар хүмүүжүүлэх зорилго тавигдаж байна⁷ гэжээ.

С. А. Далин «Алс Дорнод дахь залуучуудын хөдөлгөөний зорилго» гэдэг илтгэлдээ залуучуудын хөдөлгөөн Алс Дорнодод улс төрийн шинжтэй байна» гэдгийг тэмдэглэхийн хамт Алс Дорнодын залуучуудын хөдөлгөөнийг тодорхойлохдоо, Алс Дорнодын орнуудын залуучуудын хөдөлгөөний онцлог, нийтлэгийг заагаад, ойрын хугацаанд тэмцлийн тодорхой программа батлан гаргах хэрэгтэй байна, эс тэгвэл залуучуудын хөдөлгөөний эгнээнд харш этгээдүүдэд нэвтрэн орох бололцоотой байна гэж анхааруулжээ.

Улс бүрийн хувьсгалт залуучуудын улс төрийн зорилго нь тухайн орны бодит байдлаас шалтгаалан өөр өөр байвч ажилчид, ялангуяа тариачдын дунд их ажлыг зохиох хэрэгтэйг заажээ. Тэгвэл залуучуудын соёл гэгээрлийн ажилд татан оруулахад хялбар байдгийг илтгэгч онцлон үзсэн байна. Их хурал энэ илтгэлийг шүүмжлэн хэлэлцээд, залуучуудын хөдөлгөөний ерөнхий зорилтын тухай «Алс Дорнодын хувьсгалт залуучуудын анхдугаар их хурлын сэдвүүд»⁸ гэдэг арван зүйл бүхий баримт бичиг батлан гаргажээ. Түүнд Алс Дорнодын орнуудын залуучуудын хөдөлгөөний байдал цаашдын төлөв, залуучуудын дунд зохиох ажлын тухай тодорхой заалт оруулжээ. Их хурлаас бас Солонгос, Хятад, Япон, Монголын бүх залуучуудад зориулсан «Алс Дорнодын хувьсгалт залуучуудын их хурлын тунхаг» хэмээх баримт бичгийг батлан гаргав. Түүнд Алс Дорнодын орнуудын ард түмний амьдрал, тэмцлийн тухай, тэдгээрийн залуучуудын тухай тодорхой өгүүлээд: Нөхөд өө! Ах дүү нараа! Гадаад, дотоодын хөрөнгөтөн, газрын эзэд та нарын бие, оюун санааг боолчилж байна. Үүнээс гарах зам хаана байна? Он удсан боолчлолоос хэрхэн ангижирч байдлаа байдлаа яаж сайжруулах вэ?

Гарах зам зөвхөн хувьсгалт тэмцэлд л байна. «Иймээс бид ах дүү та нарыг хувьсгалт залуучуудын эвлэлүүд зохион байгуулахыг уриалж байна...Залуучуудын Коммунист Интернационалын тугийн дор нягтрагтун!»⁹ гэж уриалжээ. Мөн их хурлаас хөдөлмөрчин залуучуудын олон улсын нэгдлийн тухай тогтоол гаргав. Үүгээр Алс Дорнодын хувьсгалт байгууллагуудын анхдугаар их хурлын бүрэлдхүүн хэсэг хувьсгалт залуучуудын анхдугаар их хурал ажлаа дуусгасан байна.

Петроградадын зөвлөлийн урилгаар Алс Дорнодын хувьсгалт байгууллагуудын анхдугаар их хурал сүүлчийн хуралдаанаа Петроградад хийжээ. 1922 оны II сарын 2-нд сүүлчийн 12-р хуралдаа Урицкийн ордонд баяр ёслолын байдалд болж, түүнд Солонгос, Монгол, Хятад, Япон болон Алс Дорнодын эмэгтэйчүүдийн төлөөлөгчид, түүнчлэн АНУ, Францын коммунист нам, Залуучуудын Коммунист Интернационалын төлөөлөгчид үг хээлжээ. Тус хуралдаанаас Алс Дорнодын ард түмэнд хандан тунхаг гаргав. Тунхагт «Бид хувь заяандаа эзэн сууж, хомхой ховдгоороо өрсөлдөгч империалистуудын гарт тоглоом болохоо болихыг хүсч байна.

Коммунист интернационал: «Орон бүхний пролетари нар, даян дэлхий дарлагдсан улс түмэн нэгдэгтүн!» гэдэг уриа дэвшүүлэн тавьж байна.

Бид энэ уриаг манай үгүйрсэн тосгонд, боолын хүч хэрэглэсэн тариалангийн талбай, фабрик сургууль хуарангуудад хүргэх болно»

7. Дурьдсан эмхтгэл. 309-р тал.

8. Мөн тэнд. 304—308-р тал.

9. Мөн тэнд. 301-р тал.

гэж цохон тэмдэглээд тунхагийн эцэст «Зохион байгуулалттай босцгоо!, Манай дайчин эгнээнд зогсоцгоо! Капиталтай, империализмтай тэмцэхийн тулд ажилчин, тариачны эвлэл холбоо байгуулцгаа! Тэмцэлд бэлтгэгцгээе»¹⁰ гэж дурьджээ.

Их хурал, түүний секцүүдэд хэлэлцсэн асуудлууд нь Алс Дорнод, ер нь дорнодахины бүх оронд өрнөж буй хувьсгалт хөдөлгөөний тулгамдсан асуултад хариу өгсөн улс төр, практикийн их ач хобогдол бүхий шийдвэр болсон байна.

Тус их хурлын ажиллагаанд Монголоос намын төлөөлөгч 6, эвлэлийн төлөөлөгч 6 хүн оролцож илтгэл тавьжээ.

МАН-ын төлөөлөгч, МХЗЭ-ийн төлөөлөгч нараас их хуралд тавьсан илтгэлийн монгол эх нь олдоогүй байна. Коминтерний Гүйцэтгэх Хорооноос 1922 онд Петроградад орос хэлээр хэвлүүлсэн «Алс Дорнодын хувьсгалт байгууллагуудын анхдугаар их хурал» гэдэг эмхтгэлд «Я. Данзан. Монголия и её борба за существование»¹¹ «Союз революционной молодшии Монголии»¹² гэдэг хоёр материал нийтлэгджээ.

МАН-ын төлөөлөгч Дэндэвээс их хуралд тавьсан илтгэлийн эхний хэсэгт хувьсгалт Монгол Улсын тухай ерөнхий мэдэгдэхүүнийг өгүүлжээ. Үүнд: газар зүйн байршил, хил хязгаар, цаг уур, эрхэлдэг аж ахуйг дурьдаж, Монголын ард түмэн харийн түрэмгийлэлд өртөгдөж, Манжийн ноёрхол, Хятадын худалдаачдын мөлжлөгт зовж зүдэрч байсан, дараа нь XIX зууны дунд үес Оросын худалдааны капитал Монголд нэвтэрч, улмаар олон улсын капиталын нөлөөний хүрээнд алгуур татагдаж орсон, Хаант Орос улс Монголын хувьд эзлэн түрэмгийлэх бодлого явуулж байсан, Япон 1904—1905 онд Хаант Орос улстай дайтаж ялаад, зүүн Монголтой хил залгадаг Өмнөд Манжуурыг эрхшээлдээ оруулж, Азийн эх газар руу түрэмгийллээ эхэлж Монголд нэвтрэх болсныг өгүүлээд, «Орос—Японы дайны үеэс Монголыг эзлэх тухай асуудал Америкийн капиталын анхаарлыг өөртөө татаж, аажмаар олон улсын империализмын Алс Дорнодын бодлогын нэг чухал асуудал болсон юм»¹³ гэжээ. Монгол орны хөгжлийг хоёр зуу гаруй жил боогдуулж байсан Манж Чин улсын ноёрхлыг монголчууд түлхэн унагаж, тусгаар тогтнолоо тунхагласан боловч Хаант Орос улсын эдийн засгийн ноёрхолд орсон, Хаант Орос, Хятад хоёр улс Монголыг хувааж ноёрхох бодлого явуулсан. Харин дэлхийн анхдугаар дайныг япончууд Монголыг эзлэн авах аятай боломж гэж үзэж АНУ-ын ерөнхийлөгч Вильсоны худал амлалтыг магтаж, Версалийн найрамдлын бага хурлын дараа дарлагдсан бага ард түмнүүдэд эрх чөлөө, тусгаар тогтнол олгох юм шинээр суртал нэвтрүүлж байсан. Тэдний дэмжлэгээр Зүүн Монголын үндсэрхэг үзэлтнүүд Версалийн дэмжлэгт найдаж «Нармай Монгол улс» байгуулах гэж оролдоод бүтэлгүй болсон. Тэгээд империалист Япон өөртөө үнэнч, Хятадын цэргийн эрхтнүүдийн гараар Монголыг түргэн эзэлж, ЗОУ-ын Эсрэг түшиц газар болгохыг хичээсэн зэргийг илтгэлд дурьдаад: Халх (Ар Монгол-Ж. У.) –ыг Хятад эзэлсэн боловч Монголын ард түмний эх оронч хувьсгалт үзэл санаа улам сэргэж МАХН байгуулах хөрсийг бий болгосон¹⁴ гэжээ.

1920 оны дундуур Хятадад иргэний дайн гарч Японы талыг барьсан Аньфу бүлэг ялагдахын хамт империалист Японы Монголыг эзлэн

10. «Первый съезд революционных организаций Дальнего Востока» с. 5-7.

11. Дурьдсан эмхтгэл. 224-238-р тал.

12. Мөн тэнд. 329-330-р тал.

13. Дурьдсан эмхтгэл. 231-р тал.

14. Мөн тэнд. 233-р тал.

түрэмгийлэх зорилгодоо Барон Унгери тэргүүтэй Оросын цагаантныг ашигласан. МАН, ардын хувьсгалын ялалтыг зохион байгуулж, ЗОУ-ын тусламжтайгаар нутаг орноо гамин, бароны зандалчдаас чөлөөлсөн, улс орныхоо амьдралыг ардчилж, хувьсгалт өөрчлөлт хийж эхлэж байгааг заагаад, 1924 оны XI сард Зөвлөлт Орос улс Монголын төрийн тусгаар тогтнолыг хүлээн зөвшөөрсөн хэлэлцээр байгуулсан. Зөвлөлт Орос улсаас Монгол, Хятадын хоорондын харилцааг зохицуулахад зуучлаж өгөхийг Монголын ардын засгин газар хүссэнийг хүлээн авсан¹⁵ гэж цохон хэлсэн байна. Илтгэлийн гуравны хоёр хувийн ерөнхий агуулга ийм байна.

Энэ илтгэлд империалист гүрнүүдээс их, бага улсуудын тэгш эрх, эрх чөлөө, биеэ дааж тусгаар тогтнох асуудлаар баримталж байгаа бодлого нь ямагт худал хуурамч бөгөөд уг чанартаа сул дорой орныг дарлан мөлжихөд чиглэж байдгийг Монголын жишээгээр тодорхой харуулжээ. Зовлон зүдгүүр зүсэн Монголын ард түмэн МАН-ын удирдлагаар тэмцэж, ЗОУ-ын тусламжийг авснаараа ардын хувьсгалыг ялуулсан. Одоо Монгол Улсыг гадаадын эзэрхэг түрэмгий улсуудын эрхшээл нөлөөнөөс чөлөөлж, дотооддоо феодалын мөлжлөгийг зогсоон, ард олонд эрх чөлөө олгож, улсынхаа эдийн засаг, соёлыг хөгжүүлэх зорилт тавин ажиллаж байгааг нэлээд тодорхой дурьдсанаас гадна Монгол Улсын гадаад бодлогын үндэс болох ЗОУ, дэлхий дахины дарлагдсан ард түмэн ба коммунист, ажилчны намуудтай харилцаагаа бэхжүүлэх асуудал нэн тодорхой тусгагджээ. «Монголын хувьсгалт залуучуудын эвлэл» гэдэг танилцуулгын чанартай материалд МХЗЭ 1921 оны VIII сард нийслэл хүрээнд байгуулагдсан бол одоо 170 гаруй гишүүнтэй болсон. Эвлэлийн гүйцэтгэх хороо нь гурван гишүүнээс бүрддэг. Зохион зааварлах хэлтэс, соёл—гэгээрлийн хэлтэс гэсэн 2 хэлтэстэй гээд тэдгээрийн ажлын онцлогийг дурьдсан байна. Түүнчлэн «Шарын шашин залуучуудын оюун санааны хөгжлийн эрх чөлөөг саатуулж байна.»¹⁶ гээд шашны мухар сүсэг, элдэв заншлыг арилгахад МХЗЭ бүх чармайлтаа чиглүүлж байгааг өгүүлжээ. Залуучуудын бичиг үл мэдэх явдлыг арилгах, тэдэнд шинжлэх ухаан ба улс төрийн мэдлэг олгох талаар зохиож байгаа ажлаа танилцуулжээ.

Монгол залуучууд өөрийн орны улс төрийн амьдралд хамгийн идэвхтэй оролцож, хувьсгалын үйл хэргийг хамгаалахын тул зэвсэг барин тэмцэж, ноёд феодалууд хувьсгалын ялалтад дургүйцэж элдэв эсрэг явууллага хийж байгааг илрүүлж бут цохиход МХЗЭ, түүний гишүүд идэвхтэй ажиллаж байгааг уг өгүүлэлд бичсэн байна.

Монголын нам, эвлэлийн төлөөлөгчдөөс их хуралд тавьсан илтгэлүүд бол тэр үед дэлхийн олон нийтийн анхаарлыг татаж байсан Монгол оронд болсон хэрэг явдлыг үнэн зөвөөр нь тусгаснаас гадна Монгол дахь хувьсгалт тэмцэлд шууд ба шууд бусаар холбогдох олон улсын байдалд зөв дүн шинжилгээ хийсэн, империализмын эсрэг улс түмний эрх чөлөө, тусгаар тогтнолын төлөө тэмцэлд Коминтерн, ЗОУ ганц түшиг тулгуур мөн гэдгийг өөрийн орны бодит жишээгээр харуулсан олон улсын чухал ач холбогдолтой баримт бичиг мөн.

15. Мөн тэнд. 235-р тал.

16. «Первый съезд революционных организаций Дальнего Востока» Сборник. с. 329.

УЧАСТИЕ МОНГОЛЬСКИХ ДЕЛЕГАТОВ В I СЪЕЗДЕ РЕВОЛЮЦИОННЫХ ОРГАНИЗАЦИЙ ДАЛЬНЕГО ВОСТОКА

(Резюме)

МНРП с самого начала своего образования установила тесные связи с международным коммунистическим движением. Наглядным примером этого является участие делегатов МНРП, молодежной и женской организаций Монголии в первом съезде Революционных организаций Дальнего Востока, который состоялся в начале 1922 г. в Москве. Делегаты в своих выступлениях и докладах коротко и с предельной ясностью ознакомили участников съезда с ходом и результатом длительной национально-освободительной борьбы монгольского народа против чужеземных поработителей и внутренних угнетателей, большой организаторской работой МНРП по развитию и углублению Народной революции, а также проводившимся в то время в стране революционно-демократическими преобразованиями.

В статье особое внимание уделяется анализу содержания докладов и выступлений, с которыми выступили делегаты революционной Монголии на съезде революционных организаций Дальнего Востока.

ДОРНОД ТУРКСТАНЫ АРД ТҮМНИЙ ҮНДЭСНИЙ ЭРХ ЧӨЛӨӨНИЙ ТЭМЦЛИЙН ТҮҮХЭЭС

М. Хурметхан

Октябрийн социалист хувьсгалын үзэл санаа Дорнод Туркстаны ард түмнийг сэргээж, эрх чөлөө, нийгмийн дэвшлийн төлөө тэмцэлд босоход гуйлын их нөлөө үзүүлсэн юм.

Дорнод Туркстаны ард түмэн Оросын ард түмэнтэй аль хэдийнээс зүйл бүрийн холбоотой байсан нь Октябрийн хувьсгалын чөлөөлөх үзэл санаа Дорнод Туркстанд дэлгэрэхэд хамгийн тохиромжтой нөхцөл болжээ.

Октябрийн социалист их хувьсгалын шууд нөлөөгөөр Монгол оронд Ардын хувьсгалт ялсан нь хөрш зэргэлдээ Дорнод Туркстаны ард түмний үндэсний эрх чөлөөний хөдөлгөөний өрнөлтөд хувьсгалжуулагч нөлөө бас үзүүлсэн юм. Монголын Ардын хувьсгалын ялалт нь хоцрогдсон орнууд ялсан пролетарийн орны тусламжтайгаар эрх чөлөө, тусгаар тогтнолоо байлдан олж, нийгмийн дэвшлийн замаар хөгжиж болохын анхны бодит жишээг Дорнод Туркстаны ард түмэнд харуулсан юм.

Эдгээр бодит жишээг нүдээр үзсэн Дорнод Туркстан дахь уйгур, казах, монгол, узбек, киргиз, тажик, татар зэрэг ард түмэн үндэснийхээ эрх чөлөө, нийгмийн дэвшил хөгжлийн төлөө тэмцэлд зоригжин боссон түүхтэй билээ.

XX зууны 30—40 өөд онд тус нутгийн ард түмэн гоминданыхны үндэсний колончлох бодлого, нийгэм—эдийн засгийн дарлалд маш хүндээр өртсөн нь эрх чөлөөнийхөө төлөө зэвсэгт тэмцэлд босохын гол шалтгаан байв. Дорнод Туркстанд өрнөөсөн үндэсний эрх чөлөөний